



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгинохайрхан дүүргийн Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/39/НА-СТА-ОН

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Сүлд-Аудит ХХК Захирал: Ч.Гүндбаяр Утас: 70118016 Цахим хаяг: info@suld-audit.mn</p> <p>Чанарын хяналтын менежер: С.Лхагважав Утас: 99182632 Цахим хаяг: info@suld-audit.mn</p> <p>Аудитор: Г.Төрсайхан Утас: 95594404 Цахим хаяг: info@suld-audit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 576
танай _____-ны № _____-т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ТОХИЖИЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭ,
ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.БАТЖАРГАЛ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сонгинохайрхан дүүргийн Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сонгинохайрхан дүүргийн Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд зардал 1,020.2 сая төгрөгөөр өссөн гол шалтгаан нь өмнөх онуудтай харьцуулахад хур тунадас, халтиргаа гулгаа их байсан нь ажлын ачаалал үүсгэн зардлыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
1.1	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	147,119.82	93,180.92
1.1.2	Дансны авлага	377,571,365.55	481,553,506.68
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага	229,662,642.00	
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	234,566,750.00	184,459,273.76
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	13,803,240.00	39,017,190.22
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	855,751,117.47	705,123,151.58
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	826,097,466.92	2,103,589,343.29
1.2.2	Биет бус хөрөнгө	96,650,443.36	163,697,150.03
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	922,747,910.28	2,267,286,493.32
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,778,499,027.75	2,972,409,644.90
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	90,108,701.42	49,960,018.14
2.1.1.2	Цалингийн өглөг	13,030,983.66	217,144,658.66
2.1.1.3	Татварын өглөг	277,145,343.05	125,887,621.01
2.1.1.4	НДШ-ийн өглөг	447,928,606.02	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		1,552,250,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	828,213,634.15	1,945,242,297.81
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	124,970,617.62	114,458,117.64
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	124,970,617.62	114,458,117.64
2.2	Өр төлбөрийн нийт дүн	953,184,251.77	2,059,700,415.45
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: а) төрийн	595,447,360.00	595,447,360.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	53,058,518.70	53,058,518.70
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	209,000,000.00	209,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(32,191,102.72)	55,203,350.75
2.3.20	Эздийн өмчийн дүн	825,314,775.98	912,709,229.45
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,778,499,027.75	2,972,409,644.90

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	8,008,850,822.07	12,267,065,378.44
3	Борлуулалтын өртөг		
4	Нийт ашиг (алдагдал)	8,008,850,822.07	12,267,065,378.44
5	Түрээсийн орлого		
6	Хүүгийн орлого		
7	Ногдол ашгийн орлого		
8	Эрхийн шимтгэлийн орлого		
9	Бусад орлого		
10	Борлуулалт, маркетингийн зардал		
11	Ерөнхий ба удирдлагын зардал	8,118,188,031.41	12,169,960,430.17
12	Санхүүгийн зардал		
13	Бусад зардал		
14	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
15	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
17	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)		
18	Бусад ашиг (алдагдал)		
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(109,337,209.34)	97,104,948.27
20	Орлогын татварын зардал		9,710,494.80
21	Татварын дараах ашиг (алдагдал)		
22	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(109,337,209.34)	87,394,453.47
24	Бусад дэлгэрэнгүй орлого		
25	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		
26	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
27	Бусад олз (гарз)		
28	Орлогын нийт дүн	(109,337,209.34)	87,394,453.47
29	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг/алдагдал	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,447,360.00	47,940,854.50	209,000,000.00	724,479,740.59	1,576,867,955.09
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		5,117,664.20		(647,333,633.97)	(642,215,969.77)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	595,447,360.00	53,058,518.70	209,000,000.00	77,146,106.62	934,651,985.32
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-	-
7	Тайлант үеийн үр дүн	-			(109,337,209.34)	(109,337,209.34)
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,447,360.00	53,058,518.70	209,000,000.00	(32,191,102.72)	825,314,775.98
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-		-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	595,447,360.00	53,058,518.70	209,000,000.00	(32,191,102.72)	825,314,775.98
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-		-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-		-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-		-	-
7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-		-	-
8	Тайлант үеийн үр дүн	-			87,394,453.47	87,394,453.47
9	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,447,360.00	53,058,518.70	209,000,000.00	55,203,350.75	912,709,229.45

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,791,817,015.21	11,850,625,480.28
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	7,789,314,121.00	11,833,579,090.28
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	2,502,894.21	17,046,390.00
1.20	Мөнгөн зарлагын дүн (-)	7,771,852,650.62	11,825,151,719.28
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,569,892,363.73	4,085,383,158.45
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	788,708,222.55	1,806,621,157.67
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	557,410,235.00	816,131,123.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	190,502,817.45	282,638,596.20
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,989,258,714.87	2,410,208,013.98
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	63,349,751.00	570,036,430.91
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	7,144,660.00	9,257,235.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	605,585,886.02	1,844,876,004.07
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	19,964,364.59	25,473,761.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		265,000.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		265,000.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	24,341,990.00	25,792,700.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	24,341,990.00	25,792,700.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(24,341,990.00)	(25,527,700.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Бусад		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Бусад		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(4,377,625.41)	(53,939.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	171,380.12	147,119.92
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	147,119.92	93,180.92

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Д/д	Зардлын дансны нэр	2022 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү +хэмнэсэн - хэтэрсэн	Биелэлт %
Нийт орлого		8,008,850,822.00	11,265,733,269.00	12,267,065,378.44	(1,001,332,109.44)	108.9
1	Хог тээвэр	4,561,727,807.00	6,223,910,535.00	8,383,300,453.46	(2,159,389,918.46)	134.7
2	Зам талбайн /Дүүрэг/	2,348,153,100.00	3,361,137,600.00	3,136,119,660.00	225,017,940.00	93.3
3	Зам талбайн /Нийслэл/	706,081,050.00	724,151,400.00	251,567,400.00	472,584,000.00	34.7
4	Иргэдийн бүлэг	97,325,091.00	-	-	-	-
5	Ногоон байгууламж	106,143,428.00	371,094,714.00	-	371,094,714.00	0.0
6	Дүүргийн захирамжтай ажил/ хур хог зайлуулах	152,973,666.00	287,939,020.00	176,352,760.00	111,586,260.00	61.2
7	ҮИБНхороо цэвэрлэгээний ажил	35,798,000.00	-	-	-	-
8	Бусад орлого	648,680.00	297,500,000.00	319,725,104.98	(22,225,104.98)	107.5
Нийт зардал		8,118,188,031.00	11,159,444,560.60	12,179,670,924.98	(1,020,226,364.38)	109.1
1	Үндсэн цалин	3,992,774,009.00	5,036,732,010.60	5,178,337,003.06	(141,604,992.46)	102.8
2	НДШ-ийн зардал	575,441,110.00	730,326,141.54	757,778,256.93	(27,452,115.39)	103.8
3	Сэлбэг	517,660,758.00	870,000,000.00	841,231,306.00	28,768,694.00	96.7
4	Шатахууны зардал	1,292,294,094.00	1,968,125,280.00	1,556,575,226.36	411,550,053.64	79.1
5	Түрээсийн зардал	165,790,322.00	225,400,000.00	280,257,958.00	(54,857,958.00)	124.3
6	Шуудан холбоо, интернэт	2,509,267.00	13,136,000.00	3,060,900.00	10,075,100.00	23.3
7	Программ хангамж	22,966,325.00	-	-	-	-
8	Дохиоллын зардал	-	20,700,000.00	16,531,751.29	4,168,248.71	79.9
9	Авто машин татвар даатгал	16,006,459.00	16,225,474.00	17,210,475.00	(985,001.00)	106.1
10	ААНОАТатварын зардал	-	-	9,710,494.80	(9,710,494.80)	-
11	Тэтгэмж	61,887,010.00	54,000,000.00	65,826,030.00	(11,826,030.00)	121.9
12	Аж ахуй, хангамжийн зардал	467,125,746.00	284,254,000.00	486,628,268.24	(202,374,268.24)	171.2
13	Дотоод хэрэгцээ	10,971,813.00	11,474,000.00	2,760,750.00	8,713,250.00	24.1
14	Бичиг хэрэг	11,515,969.00	16,020,600.00	15,946,960.00	73,640.00	99.5
15	Хөдөлмөр хамгааллын зардал	113,009,418.00	351,580,000.00	428,705,940.00	(77,125,940.00)	121.9
16	Гэрэл цахилгааний зардал	6,771,970.00	15,600,000.00	8,513,544.91	7,086,455.09	54.6
17	Орлогын шимтгэлийн зардал	175,326,874.00	261,060,000.00	213,180,669.83	47,879,330.17	81.7
18	Засвар үйлчилгээний зардал	14,557,112.00	-	97,244,637.52	(97,244,637.52)	-
19	Ногоон байгууламж	217,907,700.00	-	-	-	-
20	Сургалтын зардал	-	-	14,275,000.00	(14,275,000.00)	-
21	Элэгдлийн зардал	249,940,812.00	411,686,340.46	415,135,235.63	(3,448,895.17)	100.8
22	Тохжилт ,ногоон байгууламж	-	371,094,714.00	1,031,920,167.01	(660,825,453.01)	278.1
23	Бусад зардал	203,731,263.00	502,030,000.00	738,840,350.40	(236,810,350.40)	147.2
Нийт ашиг /алдагдал/		(109,337,209.00)	106,288,708.40	87,394,453.46	18,894,254.94	82.2

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,672,057.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,672,057.2 мянган төгрөгийн алдааг бүрэн залруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлж орлогод авахдаа ЭӨ-ийн бусад хэсэг дансыг нэмэгдүүлсэн	1	1,663,000.0					1	1,663,000.0				
Үндсэн хөрөнгийн тайлан зөрүүтэй	1	294.3					1	294.3				
ХХОАТ-ын өглөг татварын тодорхойлолтоос зөрүүтэй	1	8,762.9					1	8,762.9				
Дүн	3	1,672,057.2					3	1,672,057.2				

Аудитаар нийт 12,791.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 5 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төлбөрийн и-баримт-гүй зардал гарсан	1	6,433.6					1	6,433.6				
Авлага, өглөгийн тооцоо нийлэлт	1	4,647.4					1	4,647.4				
Давсыг зарцуулах хэмжээ тодорхой бус	1						1					
ҮХ-ийн шинж чанартай хөрөнгө БМ-д бүртгэлтэй	1	1,710.0					1	1,710.0				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн	1	-				1	-				
Дүн	5	12,791.0				5	12,791.0				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 672,724.5 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснийг 1 төлбөрийн акт, 1 алба шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй	1	325,454.9			1	325,454.9		
Дүн	1	325,454.9			1	325,454.9		
ТХТХ-ийн хэрэгжилттэй холбоотой								
Гар утасны төлбөр, хэвлэлийн зардал гарсан	1	415.4	1	415.4				
Дүн	1	415.4	1	415.4				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Үнийн харьцуулалт хийгээгүй.	1	346,854.2					1	346,854.2
Дүн	1	346,854.2					1	346,854.2
Нийт дүн	3	672,724.5	1	415.4	1	325,454.9	1	346,854.2